

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21-р зуун цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/203/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 261628 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimegg@audit.gov.mn](mailto:erdenechimegg@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн

Захирал, ахлах аудитор: Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [ikhermurun.audit@gmail.com](mailto:ikhermurun.audit@gmail.com)

Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4-10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93  
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn  
Вэбсайт: www.audit.mn

2022.02.24 № 01/140  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙ 21-Р ЗУУН  
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.ПҮРЭВЖАЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21-р зуун цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21-р зуун цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>93,146,674.70</u></b>	<b><u>108,517,635.55</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		
35130	Эм боох материал	317,560.00	1,784,250.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		
35410	Бичиг хэргийн материал	132,400.00	697,910.00
35420	Аж ахуйн материал	12,907,848.90	268,155.00
35450	Барилгын засварын материал	2,497,800.00	6,060,000.00
35470	Бусад хангамжийн материал	75,295,065.80	97,843,320.55
35600	Мал амьтад	1,996,000.00	1,864,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,511,614,517.91</u></b>	<b><u>3,599,524,295.37</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,169,896,091.51	3,169,896,091.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-126,525,336.84	-189,288,005.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	261,790,362.69	199,111,384.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-212,913,693.56	-24,096,807.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,351,133.32	115,340,627.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-106,817,445.67	-53,411,150.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,658,275.00	53,658,275.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,680,828.54	-24,418,734.30
39217	Ном	52,840,960.00	41,122,974.25
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		
39301	Програм хангамж	1,486,600.00	594,640.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,486,600.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	311,015,000.00	311,015,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,604,761,192.61</u></b>	<b><u>3,708,041,930.92</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,604,761,192.61</u></b>	<b><u>3,708,041,930.92</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	3,204,956,346.18	3,204,956,346.18
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	-686,345,324.78	-582,321,174.93
51220	Тайлант үеийн үр дүн	-686,345,324.78	-685,601,913.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	103,280,738.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,086,150,171.21	1,085,406,759.67
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,604,761,192.61</u></b>	<b><u>3,708,041,930.92</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,586,064,887.20</b>	<b>1,699,604,213.19</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,309,344,687.20</b>	<b>148,686,638.64</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	47,099,387.20	148,686,638.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,099,387.20	148,686,638.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,911,700.00	8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	550,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,637,687.20	140,686,638.64
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,538,965,500.00</b>	<b>1,550,917,574.55</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,262,245,300.00	1,269,990,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,865,800.00</b>	<b>15,036,274.55</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,171,474.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,865,800.00	3,114,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>273,854,400.00</b>	<b>265,890,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,854,400.00	265,890,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,641,186,024.13</b>	<b>1,580,655,244.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,641,186,024.13</b>	<b>1,580,655,244.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,548,578,431.72</b>	<b>1,554,842,067.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,021,999,149.00</b>	<b>1,037,892,618.48</b>
210101	Үндсэн цалин	800,804,449.00	662,322,281.00
210102	Нэмэгдэл	142,604,801.00	318,770,338.52
210104	Урамшуулал	78,589,899.00	56,799,998.96
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>129,026,196.25</b>	<b>139,985,926.72</b>
210201	Тэтгэврийн даатгал	88,609,205.87	98,543,974.12
210202	Тэтгэмжийн даатгал	10,149,717.94	10,369,129.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,119,974.29	8,295,695.09
210204	Ажилгүйдлийн даатгал	2,013,072.69	2,070,530.14
210205	Эрүүл мэндийн даатгал	20,134,225.46	20,706,597.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>254,131,569.34</b>	<b>257,362,321.01</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,504,379.34	4,199,621.01
210302	Түлш, халаалт	246,543,240.00	251,662,700.00
210303	Цэвэр, бохир ус	4,083,950.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,680,688.00</b>	<b>8,873,437.79</b>
210401	Бичиг хэрэг	811,295.00	1,561,294.55
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,752,306.00	1,100,588.24
210404	Ном, хэвлэл	2,865,800.00	2,719,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,259,940.00	289,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,491,347.00	2,702,255.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,419,390.00</b>	<b>1,526,478.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,419,390.00	1,495,478.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	31,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,004,950.00</b>	<b>4,377,200.00</b>

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	5,004,950.00	4,377,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	100,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,377,300.00	6,320,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,377,300.00	5,312,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,008,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	113,939,189.13	98,403,585.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,111,223.00	10,729,123.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,827,966.13	87,674,462.33
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	92,607,592.41	25,813,177.55
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,000,900.00	25,399,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,010,900.00	24,349,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,990,000.00	1,050,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	14,421,130.66	378.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,421,130.66	378.99
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	58,185,561.75	413,698.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,185,561.75	413,698.56
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-55,121,136.93</b>	<b>118,948,968.31</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	15,668,230.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	15,668,230.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-15,668,230.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-55,121,136.93</b>	<b>103,280,738.31</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,204,956,346.18	1,086,856,117.37	-631,930,134.01	3,659,882,329.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,204,956,346.18	1,086,856,117.37	-631,930,134.01	3,659,882,329.54
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-55,121,136.93	-55,121,136.93
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,204,956,346.18	1,086,150,171.21	-686,345,324.78	3,604,761,192.61
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,204,956,346.18	1,086,150,171.21	-686,345,324.78	3,604,761,192.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	743,411.54	743,411.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,204,956,346.18	1,086,150,171.21	-685,601,913.24	3,605,504,604.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-743,411.54	00.00	-743,411.54
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	103,280,738.31	103,280,738.31
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,204,956,346.18	1,085,406,759.67	-582,321,174.93	3,708,041,930.92

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,546,427,200.00</b>	<b>1,558,917,574.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,269,707,000.00</b>	<b>8,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,461,700.00	8,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,461,700.00	8,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,911,700.00	8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	550,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,538,965,500.00</b>	<b>1,550,917,574.55</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,262,245,300.00	1,269,990,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,865,800.00</b>	<b>15,036,274.55</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,171,474.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,865,800.00	3,114,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>273,854,400.00</b>	<b>265,890,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,854,400.00	265,890,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,540,808,100.00</b>	<b>1,504,627,574.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,540,808,100.00</b>	<b>1,504,627,574.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,448,245,507.59</b>	<b>1,478,814,397.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,021,999,149.00	1,037,892,618.48
210101	Үндсэн цалин	800,804,449.00	662,322,281.00
210102	Нэмэгдэл	142,604,800.00	318,770,338.52
210104	Урамшуулал	78,589,900.00	56,799,998.96
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	129,026,196.25	139,985,926.72
210201	Тэтгэврийн даатгал	88,609,205.87	98,543,974.12
210202	Тэтгэмжийн даатгал	10,149,717.94	10,369,129.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,119,974.29	8,295,695.09
210204	Ажилгүйдлийн даатгал	2,013,072.60	2,070,530.14
210205	Эрүүл мэндийн даатгал	20,134,225.55	20,706,597.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	254,131,569.34	257,362,321.01
210301	Гэрэл, цахилгаан	3,504,379.34	4,199,621.01
210302	Түлш, халаалт	246,543,240.00	251,662,700.00
210303	Цэвэр, бохир ус	4,083,950.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,245,093.00	8,342,762.79
210401	Бичиг хэрэг	916,200.00	1,420,754.55
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,752,306.00	1,100,588.24
210404	Ном, хэвлэл	2,865,800.00	3,191,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,191,500.00	835,820.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,019,287.00	1,294,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,799,200.00	430,168.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,929,500.00	399,168.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	869,700.00	31,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,591,700.00	8,527,900.00
210604	Урсгал засвар	5,591,700.00	8,527,900.00

2107	Томилолт, зочны зардал	00.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,418,300.00	10,268,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	818,300.00	9,260,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,034,300.00	15,904,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,034,300.00	15,904,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>92,562,592.41</b>	<b>25,813,177.55</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,955,900.00	25,399,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,010,900.00	24,349,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,945,000.00	1,050,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,421,130.66	378.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,421,130.66	378.99
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,185,561.75	413,698.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,185,561.75	413,698.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>5,619,100.00</b>	<b>54,290,000.00</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>5,567,600.00</b>	<b>54,290,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>5,567,600.00</b>	<b>54,290,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	5,567,600.00	54,290,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,567,600.00	54,290,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>-5,567,600.00</b>	<b>-54,290,000.00</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	51,500.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,543,881,300.00	1,543,467,222.45	414,077.55	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,543,881,300.00	1,543,467,222.45	414,077.55	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,518,482,200.00	1,518,068,122.45	414,077.55	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,037,937,800.00	1,037,892,618.48	45,181.52	100.0
210101	Үндсэн цалин	662,367,300.00	662,322,281.00	45,019.00	100.0
210102	Нэмэгдэл	318,770,500.00	318,770,338.52	161.48	100.0
210104	Урамшуулал	56,800,000.00	56,799,998.96	01.04	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,121,600.00	139,985,926.72	135,673.28	99.9
210201	Тэтгэврийн даатгал	98,604,100.00	98,543,974.12	60,125.88	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	10,379,400.00	10,369,129.83	10,270.17	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,303,500.00	8,295,695.09	7,804.91	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,075,900.00	2,070,530.14	5,369.86	99.7
210205	Эрүүл мэндийн даатгал	20,758,700.00	20,706,597.54	52,102.46	99.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	257,362,700.00	257,362,321.01	378.99	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	4,199,621.01	378.99	100.0
210302	Түлш, халаалт	251,662,700.00	251,662,700.00	00.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,296,400.00	4,256,488.24	39,911.76	99.1
210401	Бичиг хэрэг	600,600.00	600,600.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,600.00	1,100,588.24	11.76	100.0
210404	Ном, хэвлэл	500,500.00	471,400.00	29,100.00	94.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,300.00	289,500.00	10,800.00	96.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,294,400.00	1,294,400.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	231,200.00	230,168.00	1,032.00	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,200.00	199,168.00	1,032.00	99.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,000.00	31,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,217,900.00	60,067,900.00	150,000.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,140,000.00	44,990,000.00	150,000.00	99.7
210602	Тавилга	6,550,000.00	6,550,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	8,527,900.00	8,527,900.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	100,900.00	100,000.00	900.00	99.1
210702	Дотоод албан томилолт	100,900.00	100,000.00	900.00	99.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,309,500.00	2,268,500.00	41,000.00	98.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,301,500.00	1,260,500.00	41,000.00	96.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад	15904200.00	15904200.00	00.00	100.0

	зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,904,200.00	15,904,200.00	00.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25399100.00</b>	<b>25399100.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	00.00	00.00	00.00	0.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,399,100.00</b>	<b>25,399,100.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,349,100.00	24,349,100.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,050,000.00	1,050,000.00	00.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,543,881,300.00</b>	<b>1,543,467,222.45</b>	<b>414,077.55</b>	<b>100.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,269,990,700.00</b>	<b>1,269,577,001.44</b>	<b>413,698.56</b>	<b>100.0</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,269,990,700.00	1,269,577,001.44	413,698.56	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>265,890,600.00</b>	<b>265,890,221.01</b>	<b>378.99</b>	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	265,890,600.00	265,890,221.01	378.99	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>8,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	8,000,000.00	00.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>78.00</b>	<b>78.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	57.00	57.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,036,274.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,036,274.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>15,036,274.55</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,086,274.55</b>
210401	Бичиг хэрэг	820,154.55
210404	Ном, хэвлэл	2,719,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	546,320.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>200,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,000,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2750000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,750,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>15036274.55</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,036,274.55</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,171,474.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,114,800.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ихэр мөрөн аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бөгөөд 2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг хүүхдийн хөгжил, нас бие сэтгэхүйн онцлогт тохируулан явуулах, сургалтын сайн арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажиллах зорилгын хүрээнд 12 зорилт тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,641.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 32.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103.3 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансны үзүүлэлттэй холбоотой байна.

/Сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	00	00	
Урьдчилгаа	00	00	
Бараа материал	93.1	108.5	15.4
Үндсэн хөрөнгө	3,511.6	3,599.5	87.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,604.7</b>	<b>3,708.0</b>	<b>103.3</b>
Өр төлбөр	00	00	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,604.7	3,708.0	103.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,604.7</b>	<b>3,708.0</b>	<b>103.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 108.5 сая төгрөг болж 15.4 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 49.4 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээж авсан 12.3 сая төгрөг, мал амьтад дансанд нас дэвшүүлсэн бүртгэл 0.9 сая төгрөг, малын төл 0.3 сая төгрөгөөр нэмэгдэж үйл ажиллагаанд 43.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын малын эмчийн актыг үндэслэн хорогдсон төлөг 3 ширхэг, ямаа 5 ширхэгийн тус тус акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 3,599.5 сая төгрөг болж 87.9 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан машин тоног төхөөрөмж дансанд төсвийн хөрөнгөөр 45.9 сая төгрөгөөр компьютер, техник хэрэгсэл, 13.3 сая төгрөгөөр тавилга эд хогшил, үнэ төлбөргүй хүлээн авсан 28.2 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмж нэмэгдсэн байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1/1208 дугаар албан бичгээр 19.6 сая төгрөгийн багаж техник хэрэгсэл, тавилга эд хогшил худалдан авах зөвшөөрөл олгосон байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, "0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 19 нэр төрлийн 255.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, өртгийг шинэчлэн 41.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дүгээр 109 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 19 ширхэг 6.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, 272 нэр төрлийн 15.7 сая төгрөгийн ном, сурах бичгийг акталж данснаас хассан. Хуримтлагдсан элэгдэл дансанд 87.7 сая төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,708.0 сая төгрөг болж 103.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 113.5 сая төгрөгөөр буюу 7.2 өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого данс байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг 1,580.7 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад 60.5 сая төгрөгөөр буурч, нийт үр дүн 158.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант оны төсвийг 1,417.5 сая төгрөгөөр төсөвлөн хүргүүлсэн байх бөгөөд Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 1,434.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор 83.4 сая төгрөгний тодотгол цалин, урамшуулалын зардалд, Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоолоор өөрийн орлогийн 8.0 сая төгрөг нэмэгдэж төсөв 1,525.5 сая төгрөг болсон байна. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар нэг удаа нэмэх тодотголтой зохицуулалт хийж 18.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсөв 1,543.9 сая төгрөг болсон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг 1,543.5 сая төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төлөвлөгөө 1,543.9 сая төгрөгтэй харьцуулахад 99.9 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн 0.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд үдийн цай, түлш халаалтын зардлаас хэмнэсэн 36.9 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зохицуулалт хийсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсролын газраас ариутгалын зардалд 0.2 сая төгрөг, боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд 8.0 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-аас ариутгалын зардалд 3.1 сая төгрөг, тендерийн орлого 0.2 сая төгрөг, түрээсийн номны төлбөр 2.7 сая төгрөг, Эрүүл мэндийн газраас шагналд 0.2 сая төгрөг, Боловсролын үнэлгээний төвөөс дэвтэр засалтын үнэ 0.4 сая төгрөг, ЭЕШ зохион байгуулсан бичиг хэргийн зардалд 0.2 сая төгрөг нийт 15.0 сая төгрөгийн орлогыг хүлээн авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургууль нь 2021 онд нийт 2,329.5 сая төгрөгийн 82 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,329.5 сая төгрөгийн 82 мэдээллийг ил тод байршуулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан тасалбар болгосон ба тайланг батламжилсан өдрийн хооронд тайланд нөлөө үзүүлж болохуйц үйл явдал болоогүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 223.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 223.2 сая төгрөгийн зөрчлийг аудитын хугацаанд залруулсан.

### **4.1 Залруулсан алдаа**

1. Ерөнхий журналд 41.3 сая төгрөгийн 14 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн.
2. Бараа материалын тодруулагад 12.3 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг аж ахуйн материал дансанд бүртгэсэн.
3. Тээвэр шатахууны зардал 0.2 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн зардалд, шуудан холбооны зардал 0.01 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд бүртгэсэн.
4. Үндсэн хөрөнгийн тодруулагад үнэ төлбөргүй хүлээн авсан 24.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсанаар бүртгэсэн.
5. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилтийн дүнг 144.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан алдаа зөрчлийг аудитын хугацаанд залруулав.

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

### **4.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Ирээдүй 21- р зуун цогцолбор сургууль	6	223.2	6	223.2	-	-	-	-	-	-

**БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо: 2022.02.23

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо:

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Ц.МӨНХТУЯА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

